



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/395

Булган сум

Байкал Тревэл Экспо үзэсгэлэн яармагт оролцож, орон нутгаа сурталчлах ажлыг зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын хүрээнд Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотноо зохион байгуулагддаг “Байкал Тревэл Экспо” үзэсгэлэн яармагт оролцож, орон нутгаа сурталчлах арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд чанарын өндөр түвшинд зохион байгуулж, тайлагнахыг аймгийн Аялал жуулчлалын холбооны тэргүүн (Г.Чимгээ)-д үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 19-ны/ний өдрийн А/ЗС дугаар
захирамжийн хавсралт

**БАЙКАЛ ТРЕВЭЛ ЭКСПО ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГТ ОРОЛЦОЖ,
ОРОН НУТГАА СУРТАЛЧЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ**

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ (рубль)	Нийт үнэ (рубль)	Нийт үнэ (төгрөг)
1	2	3	4	5	6	7
1	Үзэсгэлэнгийн асар	2 өдөр	1 ш	3500	7000	262,500
2	Уулзалтын өрөө түрээс	Өрөө	2 цаг	1500	3000	112,500
3	Зочид буудал	Хүн	4	5200	5200	195,000
4	Хоол	Хүн	4	2000	8000	300,000
Хэсгийн дүн					23500	870,000
№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
5	Унаа	Хүн	4	130,000*2	1,040,000	
6	Постер	ш	1	250,000	250,000	
7	Тараах материал	ш	560	1500	840,000	
Хэсгийн дүн					2,130,000	
Нийт					3,000,000	